



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №10


2019 оны 3-р сарын 25-29

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ


Улсын хэмжээнд 2019 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт 68 яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 48(70.5%) галзуугийн эрсдэлд өртсөн, 13(19%) хачигт халдвар, боом 1(1.5%), 2(3%) хумхаа, 1(1.5%) ям, 2(3%) денги, 1(1.5%) бэтэг өвчний сэжигтэй тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

1.1. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:

Булган, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хэнтий, Хөвсгөл, Завхан аймгийн 18 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт 48 тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4%-иар их байна. Эпидемиологийн 12-р долоо хоногтой харьцуулахад адил үзүүлэлттэй байна.



Галзуу өвчний сэжигтэй зэрлэг, мал амьтанд уруулж, ноцуулан, шүлсдүүлсэн хүмүүсийн тохиолдлыг эх уурхайгаар нь авч үзвэл: эзэнтэй нохойд (31.3%), чононд (25%) үнэгэнд (14.6%), эзэнгүй нохойд (14.6%), мануулд (6.3%), үхэрт (4.2%), тэмээнд (2.1%) нь уруулсан байна.




Энэ долоо хоногт

Эрсдэлд өртсөн 1 тохиолдол: Өмнөговь аймгийн Даланзадгад сумын харьяат. 13 настай, эрэгтэй. 2019 оны 3-р сарын 22-ны 20:00 цагийн орчим хамар, баруун нүдний доод зовхи, зүүн хонгондоо нохойд уруулсан шархтай. 3-р сарын 22-ны 22:00 цагийн орчимд эмнэлэгт үзүүлж шархны анхны цэгцлэлт, ариун боолт хийлгэж, галзуугийн эсрэг вакцинд хамрагдсан. ЗӨСҮТ-ээс 3-р сарын 23-нд галзуугийн эсрэг ийлдэс хүргүүлсэн. Нохойг (эзэнтэй) уяж хяналтад авсан.

Эрсдэлд өртсөн 2 тохиолдол: Өвөрхангай аймгийн Нарийнтээл суманд галзуу өвчний эрсдэлд өртсөн 2 тохиолдол бүртгэгдсэн байна. 2019 оны 3-р сарын 18-ны шөнө нохойд уруулсан. Эрсдэлд өртсөн тохиолдлууд галзуу өвчний эсрэг вакцин, ийлдэс эмчилгээнд хамрагдсан байна. Нохойг устгаж аймгийн МЭАЦЛ-д шинжлүүлэхэд 3-р сарын 22-нд галзуу өвчин болох нь тогтоогдсон. Өвөрхангай аймгийн ЗӨСТ нийт 7 өрх айлын хүн амд сургалт сурталчилгаа хийсэн байна.

1.2 Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:

Баянхонгор, Булган, Дорнод, Говьсүмбэр, Өмнөговь, Ховд, Хэнтий аймгийн 10 сум, нийслэлийн 2 дүүрэгт хачгаар дамжих халдварын 7 сэжигтэй тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 8.3%-иар, эпидемиологийн 12-р долоо хоногтой харьцуулахад 2 тохиолдлоор тус тус илүү үзүүлэлттэй байна.



Энэ долоо хоногт Ховд аймгийн (Мөст-1, Манхан-1, Жаргалант-1), Өмнөговь аймгийн (Номгон), Хэнтий аймгийн (Хэрлэн), Булган аймгийн (Булган) сумдаас хачгаар дамжих халдварын хачигт риккетсиозын онош тодруулахаар 6 хүний хүний сорьц дээжилж илгээсэн. ЗӨСҮТ-ийн Лавлагаа лабораторит Өмнөговь, Хэнтий аймгаас онош тодруулахаар илгээсэн хачигт риккетсиозын сорьцод шинжилгээ хийгдсэн. Лабораторийн шинжилгээний дүнг албан тоотоор хүргүүлсэн.

Мөн Булган аймгийн Булган сумаас хачигт риккетсиозын онош тодруулах сорьцонд шинжилгээ хийхээр хүлээн аваад байна. 52 настай, эмэгтэй. 2019 оны 3-р сарын 21-нд дагзны хэсэгт хачигт хазуулсан өгүүлэмжтэй. 3-р сарын 23-нд халуурах, хачиг хазсан хэсэгт үрэвсэх шинж тэмдэг илэрч, 3-р сарын 28-нд Булган сумын Нэгдсэн эмнэлэгт хэвтсэн байна. Одоогийн байдлаар биеийн байдал тогтвортой байна. ЗӨСҮТ онош тодруулахаар сорьц материалд лабораторийн шинжилгээ хийхээр хүлээн аваад байна.

1.3 Боомын хүний өвчний сэжигтэй тохиолдол:

Ховд аймгийн Мөст сумаас боомын арьсны хэлбэрийн хүний өвчний сэжигтэй 1 тохиолдол бүртгэгдсэн. Тархвар судлал, эмнэлзүйн шинж тэмдэг, лабораторийн шинжилгээгээр тохиолдол үгүйсгэгдсэн байна.

1.4 Денгийн чичрэг хүний өвчний сэжигтэй тохиолдол:

ХӨСҮТ-өөс Денгийн чичрэг хүний өвчний 1 сэжигтэй тохиолдол бүртгэгдэж, онош тодруулахаар шинжилгээнд сорьц дээжилж ЗӨСҮТ-ийн лавлагаа, лабораторийн шинжилгээгээр хумхаа болон денги өвчний үүсгэгч илрээгүй байна.

Монгол улсад:

Галзуу өвчний мал, амьтны өвчлөл:

Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Өндөр хөмөг багийн “Өр-Өлтийн бизьяа” гэдэг газар малчин “Л”-ийн 1 нохой 3-р сарын 21-ний өдөр галзуу өвчний шинж тэмдэгтэй хорогдсон тул дээж авч аймгийн МЭАЦЛ-д шинжлүүлэхэд галзуу өвчин болох нь тогтоогдсон. Тус сумын Засаг даргын захирамжаар 3-р сарын 22-нд 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоосон. Голомтод нийт 11 нохойг вакцинжуулсан.

Эх уурхай: ОБЕГ

Шүлхий өвчин:

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Агаруут багийн “Тал хонгор” гэдэг газар 3-р сарын 19-нд 5 айлын нийт 42 тоо толгой мал, мал амьтны гоц халдварт шүлхий өвчний шинж тэмдэгтэй өвчилсөн тул дээж авч аймгийн МЭАЦЛ-д шинжлүүлэхэд шүлхий өвчин болох нь тогтоогдсон байна. Тус сумын Засаг даргын захирамжаар 3-р сарын 20-нд хорио цээрийн дэглэм тогтоосон. Голомтод нийт 46 малыг тусгаарлаж, 3775 малыг вакцинжуулсан байна.

Эх сурвалж: ОБЕГ

Галзуу өвчний мал, амьтны өвчлөл:

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өлзийт багийн малчин “Т”-ийн 1 үхэр 2019 оны 3-р сарын 22-ны өдөр галзуу өвчний шинж тэмдэгтэй хорогдсон тул дээж авч аймгийн МЭАЦЛ-д шинжлүүлэхэд галзуу өвчин болох нь тогтоогдсон. Тус сумын Засаг даргын захирамжаар 3-р сарын 25-нд 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоосон байна.


Эх сурвалж: ОБЕГ

ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ


Олон улсад:

Эбола вируст халдвар:

2019 оны 3-р сарын 21-ний өдрийн ДЭМБ-ын мэдээлснээр Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад Эбола вируст халдварын сэжигтэй 980 тохиолдол (915 батлагдсан, 65 болзошгүй) бүртгэгдэж, үүнээс 610 (62%) нь нас барсан тухай нийтэлсэн байна.



Нийт тохиолдлын 554 (57%) нь эмэгтэйчүүд, 293 (30%) нь 18-аас доош насны хүүхдүүд тус тус эзэлж байна. Тус улсад тандалт судалгаа үргэлжилж байна.




Зураг 1. Эбола вирус халдвар, Бүгд Найрмдах Ардчилсан Конго улс

Эх үүрхэй: ДЭМБ

Гахайн сонгомол мялзан өвчин:

Япон улсын Мал амьтны эрүүл мэндийн газрын 2019 оны 3-р сарын 26-ны өдрийн мэдээгээр Гифу мужийн Яамагата хотын гахайн фермд 3-р сарын 22-нд Гахайн сонгомол мялзан өвчин бүртгэгдсэн тухай нийтэлжээ. Нийт 17 гахай өвчилж, 3637 гахайг устгасан байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Африкийн гахайн мялзан өвчин:

Румын улсын Тульсиа мужид Африкийн гахайн мялзан өвчин бүртгэгдсэн талаар Хөдөө аж ахуйн яамнаас 2019 оны 3-р сарын 27-ны өдөр мэдээлсэн байна. Цэцэрлэгт хүрээлэнд 1 зэрлэг гахай өвчилсөн тул гахайг устгасан байна.

Эх сурвалж: ДАЭМБ

MERS-CoV-ийн халдвар:

Саудын Араб улсын эрүүл мэндийн яамны 13 дугаар долоо хоногийн мэдээгээр MERS-CoV-ийн 3 тохиолдол бүртгэгдсэн байна.

Эхний тохиолдол: 61 настай, эрэгтэй. Хамесс Мэйсайт хотын Асээр дүүрэгт амьдардаг.

Хоёрдахь тохиолдол: 57 настай, эрэгтэй. Алхарж хотын Ридах дүүрэгт амьдардаг.

Гуравдахь тохиолдол: 60 настай, эмэгтэй. Хубооб хотын Алшиа дүүрэгт амьдардаг. Дээрх 3 тохиолдол тэмээтэй хавьтал болсон өгүүлэмжгүй байна. Саудын Араб улсад 2019 оны 3-р сарын байдлаар MERS-CoV-ийн халдвар нийт 107 тохиолдол бүртгэгдсэн тухай нийтэлсэн байна.

Эх сурвалж: Promed

Энэ долоо хоногт үйл явдалд суурилсан тандалтын мэдээг Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Багануур, Хэнтий, Ховд, Өмнөговь, Өвөрхангай, Говь-Алтай, Завхан, Сэлэнгэ аймгууд ирүүлсэн байна.